Монгол Улсын Засгийн газраас баталсан “Дэлхийн Монголчууд” хотолборийн хvрээнд 2018 оны 9 дvгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан “Хилийн чанад дахь монголчуудын холбоо, ТББ-уудын III чуулга уулзалт”-ын дvнд “Алдарт эх” одонг хилийн чанадад суугаа болзол хангасан эхчvvдэд суугаа оронд нь олгож байхаар тохирсны дагуу дараах материалыг тус ЭСЯ-нд бvрдvvлж огно vv. Үvнд:

1. Одон олгож огохийг хvссэн оргодол (*Монгол Улсын Ерөнхийлөгчид хандсан)*;

2. Эхийн иргэний цахим vнэмлэхний хуулбар;

3. Хvvхдvvдийн торсний гэрчилгээ, иргэний vнэмлэхний хуулбар;

*4.* Хvvхэд vрчилж авсан бол vрчлэлтийн гэрчилгээ эсвэл хvvхэд vрчилсэн тухай архивын лавлагаа *(хvvхдийг заавал 3 наснаас өмнө vрчилж авсан байх ёстой);*

5. Анкет /анкетийг энд дарж авна уу/

Олон хvvхэд торvvлж осгосон эхийг дараах одонгоор шагнана:

- Зургаан хvvхэд торvvлж осгосон эхийг “Эхийн алдар” нэгдvгээр зэргийн одонгоор,

- Дорвон хvvхэд торvvлж осгосон эхийг “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одонгоор шагнана.

*(“4 буюу тvvнээс дээш хvvхэд төрvvлж өсгөсөн” гэдэгт бага хvvхэд нь нэг нас хvрэхэд 4 ба тvvнээс дээш хvvхэдтэй байсан бөгөөд vvнд тэр vед 3 хvртэлх насанд vрчлэн авсан хvvхэд хамаарах ба харин эхийн төрvvлж бусдад vрчлvvлсэн хvvхдэд хамаарахгvй болно).*

Стокхолм дахь Монгол Улсын Элчин сайдын яам